

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ГЭРЭЭ

Монгол улсын Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх заалт, Гаалийн тухай хуулийн 28 дугаар зүйлийг үндэслэн нэг талаас Монгол улсын засгийн газрыг төлөөлж Монгол Улсын Сангийн сайд /цаашид "Сайд" гэнэ/, нөгөө талаас Тогтвортой байдлын гэрээ байгуулахаар хүсэлт гаргасан Монгол улсад үүсгэн байгуулагдсан, аж ахуйн нэгжийн 26/3174 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахыг зөвшөөрсөн 03-254 дугаартай гэрчилгээтэй, гаалийн тусгай бүс байгуулан ажиллуулах Гаалийн ерөнхий газрын даргын 489 тоот тушаалаар олгогдсон зөвшөөрлөөр гаалийн тусгай бүс байгуулан үйл ажиллагаа явуулах "Эрин интернэшнл" ХХК-ийн Япон талын хөрөнгө оруулагч "Дайнем инвестмент" ХХК /цаашид "Хөрөнгө оруулагч" гэнэ/-тай хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаа явуулах татварын орчныг тодорхой хугацаанд тогтвортой байлгах баталгаа болгож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээгээр зохицуулах зүйл

1.1. Энэхүү Гэрээ нь хөрөнгө оруулагч Монгол улсын Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт газар эзэмших эрхийн 0001701 дугаар гэрчилгээгээр олгогдсон 19.3 га буюу 193488 кв.м бүхий газарт гаалийн тусгай бүсийн үйл ажиллагаа явуулахад нь татварын тогтвортой нөхцөлөөр хангах, тухайн хөрөнгө оруулалтын зорилго, хэмжээ, гэрээг цуцлах үндэслэл, хэрэгжүүлэх хугацаа, гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Үндсэн нөхцөл

2.1. "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай" хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын хэмжээ нь 2.0 сая ам доллараас доошгүй байх тул 10 /арван/ жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

2.2. Хөрөнгө оруулагчийн төлбөл зохих аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 0-100.000.000 төгрөгийн албан татвар ногдуулах жилийн орлогод 15 хувиар, 100.000.000-аас дээш төгрөгийн албан татвар ногдуулах жилийн орлогод 15.000.000 төгрөг дээр 100.000.000 төгрөгнөөс дээш орлогын дүнгийн 30 хувиар, импортын барааны гаалийн албан татвар 5 хувь, нэмэгдсэн өртөгийн албан татвар 15 хувь буюу энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед үйлчилж байгаа хууль тогтоомжид заасан хувь хэмжээнд байна.

2.3. Гаалийн тусгай бүсэд хилийн чанадаас оруулах барааг Монгол Улсын "Гаалийн тухай" хуулийн 31 дүгээр зүйлийн дагуу зохицуулна.

2.4. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байгаа "Гаалийн тухай хууль", "Гаалийн тарифын тухай" хууль болон бусад хууль, тогтоомжид заасан гаалийн тусгай бүсийн горимын дагуу хөрөнгө оруулагч "Гаалийн тусгай бүс"-ийн үйл ажиллагаагаа явуулна.

Гурав. Гэрээний хугацаа

3.1. Гэрээг 2005 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 2015 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл 10 жилийн хугацаатай байгуулав.

Дөрөв. Хөрөнгө оруулагчийн үүрэг, эрх

4.1 Хөрөнгө оруулагч Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, Монгол улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

4.2. Хөрөнгө оруулагч гэрээний хугацаанд үйл ажиллагаагаа тогтмол, хэвийн явуулах үүрэгтэй.

4.3. Хөрөнгө оруулагч энэхүү гэрээнд гарын үсэг зурснаас хойш нийт 2 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг дараах хуваарийн дагуу хийнэ:

Хөрөнгө оруулалтын жил	Хугацаа	Хөрөнгө оруулалтын хэмжээ /сая ам.доллар/	Үүнээс	
			Мөнгөн хэлбэрээр	Бусад хэлбэрээр
1	2005 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс 2006 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл	-	-	
2	2006 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс 2007 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл	0.5		0.5
3	2007 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс 2008 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл	0.5		0.5
4	2008 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс 2009 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл	0.5		0.5
5	2009 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс 2010 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл	0.5		0.5
	Нийт дүн	2.0		2.0

4.4. Энэхүү гэрээнд гарын үсэг зурагдах үед хөрөнгө оруулагч анхны хөрөнгө оруулалт болох 2.0 сая ам долларын хөрөнгө оруулалтыг хийсэн тул 4.3-т заасан хөрөнгө оруулалтын хуваарьт өөрчлөлт оруулж болно. 4.3-т заасан энэхүү хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулагч болон гаалийн тусгай бүсэд хөрөнгө оруулах бусад компаниудын /цаашид "Холбогдох компани" гэх/ мөнгөн болон бусад хэлбэрээр оруулсан хөрөнгө оруулалтыг тооцно.

4.5. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дараагийн жилийн мөн өдрийг хүртэлх хугацааг энэхүү гэрээний хувьд "Хөрөнгө оруулалтын жил" гэж үзнэ.

4.6. Хөрөнгө оруулагч нь тухайн хөрөнгө оруулалтын жилд оруулсан хөрөнгө оруулалтын тайлангаа дараагийн хөрөнгө оруулалтын жилийн эхний сард багтаан Сангийн яамнаас баталсан маягтын дагуу гаргаж, тухайн салбарыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан Сайдад хүргүүлнэ.

4.7. Хөрөнгө оруулагч бүтээгдэхүүнээ борлуулснаас олсон орлогоо Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй аль нэг арилжааны банкинд нээсэн дансанд эхлэн байршуулах бөгөөд уг төгрөгийн болон валютын орлогоо хөрөнгө оруулагч өөрөө гадаадад болон дотоодод захиран зарцуулах эрхтэй байна.

4.8 Хөрөнгө оруулагч нь тухайн хөрөнгө оруулалтын жилд төлөвлөснөөс илүү хөрөнгө оруулалт хийсэн нөхцөлд давсан хэсгийг дараагийн жилүүдийн хөрөнгө оруулалтад оруулж тооцох эрхтэй.

4.9. Хөрөнгө оруулалтыг бэлэн мөнгө, техник, тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материал, оюуны өмч болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад байдлаар хийх эрхтэй.

4.10. Сайд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас Тогтвортой байдлын гэрээний баталгаа алдагдсан тохиолдолд Хөрөнгө оруулагч баталгааг сэргээлгэх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр хуульд заасан журмын дагуу нэхэмжлэх эрхтэй.

Тав. Сайдын үүрэг, эрх

5.1. Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаагаа явуулах орчныг гэрээний хугацаанд тогтвортой байлгах талаар энэхүү гэрээнд заасан баталгаа, нөхцөлөөр хангах үүргийг хүлээнэ.

5.2. Тогтвортой байдлын гэрээнд гарын үсэг зурсны дараа уг гэрээний нөхцлийн тухай мэдэгдлийг холбогдох газруудад хүргүүлнэ.

5.3. Хөрөнгө оруулагч 4.3-т заасан хөрөнгө оруулалтаа хийж байгаа эсэхэд Сайд тухайн салбарыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хяналт тавина.

5.4. Хөрөнгө оруулагч энэхүү гэрээний 4.3-т заасан хэмжээ, хугацаанд хөрөнгө оруулахаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй 6 сар өнгөрвөл Сайд энэ тухай хөрөнгө оруулагчид бичгээр мэдэгдэл өгнө.

5.5. Мэдэгдэл өгснөөс хойш ажлын 30 хоногийн дотор Хөрөнгө оруулагч уг мэдэгдэлд заасан үүргийг биелүүлэх талаар зохих арга хэмжээ аваагүй тохиолдолд Сайд дангаар гэрээг цуцлах эрхтэй.

Зургаа. Гэрээ дуусгавар болох

6.1. Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно:

6.1.1. Гэрээний хугацаа дууссан тохиолдолд;

6.1.2. Хөрөнгө оруулагч гэрээг цуцлах тухай хүсэлт гаргасны дагуу хоёр тал харилцан тохиролцсон тохиолдолд;

6.1.3. Аж ахуйн нэгж дампуурсан, хууль тогтоомж зөрчсөний учир эрх бүхий байгууллагаас үйл ажиллагааг нь бүрэн зогсоосон тохиолдолд;

Долоо. Бусад зүйл

7.1. Энэхүү Гэрээний үүргийн биелэлттэй холбогдон аливаа маргаантай асуудал үүсвэл Талууд хэлэлцэн тохиролцох замаар шийдвэрлэнэ. Нэгдсэн шийдэлд хүрээгүй тохиолдолд маргааныг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

7.2. Гэрээг 2005 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Улаанбаатар хотод Монгол, Англи хэл дээр тус бүр 2 хувь үйлдэж баталгаажуулав.

7.3. Хувиуд нь адил хүчинтэй бөгөөд хэрэв гэрээг хэрэгжүүлэх, тайлбарлахад маргаан гарвал монгол хэл дээрх эх бичвэрийг баримтална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

